ГЭР БҮЛ ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН 2017 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

| **Хөтөлбөр** (хөтөлбөрийн нэр), **хэрэгжүүлэх арга хэмжээ** | **Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт** | | **Хэрэгжилт** | **Хэрэгжилтийн хувь** |
|---|---|---|---|---|
| | **Арга хэмжээ (гарц)-ний шалгуур үзүүлэлт** /тоо, чанар, хугацаа/-**ийн хүрэх түвшин** | **Хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин** | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| **Нэг. “Гэр бүл, хүүхэд, залуучуудад чиглэсэн хөгжил, хамгааллын үйлчилгээний хүрээ, нэр төрлийг хөгжүүлэх, чанартай шуурхай үйлчилгээг өргөжүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ** | | | | |
| 1.1. Хүүхэд хамгааллын дэлхийн 7 хоног аяныг зохион байгуулах | **Тоо:** 1 удаа<br>**Чанар:** Удирдамж гарсан байх<br>-Хүүхэд хамгааллын аян зохион байгуулагдсан байх<br>-3000 иргэд, хүүхэд, үүрэг хүлээгчдийг хамруулсан байх<br>**Хугацаа:**2-р улирал | Удирдамжийн дагуу аян зохион байгуулж үр дүнг тайлагнасан байна. | Хүүхдийн эсрэг хүчирхийллийг зогсооход эх дэлхийгээрээ нэгдье” хүүхэд хамгааллын аяныг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын санаачлагаар “Дэлхийн Зөн” ОУБ-ын дэмжлэгтэйгээр 5 жилийн хугацаатайгаар улс даяар эхлүүлээд байгаа билээ. Тус ажлын хүрээнд Дундговь аймгийн Засаг даргын 2017 оны 09 дугаар сарын 13-ны өдрийн А/319 дугаар захирамжаар “Хүүхдийн эсрэг хүчирхийллийг зогсооход эх дэлхийгээрээ нэгдье” хүүхэд хамгааллын 7 хоногийн аяныг зохион байгуулах ажлын хэсгийг томилон 2017 оны 09 дүгээр сарын 25-29-ний өдрүүдэд амжилттай зохион байгууллаа.<br>Тус аяныг зохион байгуулах ажлын хэсгийг гишүүдийг чадваржуулах өртөөчилсөн | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | сургалтад хамруулан, 2017.09.25-нд “Хүүхдийн эсрэг хүчирхийллийг зогсооход эх дэлхийгээрээ нэгдье” хүүхэд хамгааллын 7 хоногийн аяны нээлтийн үйл ажиллагааг зохион байгууллаа. Хүүхэд хамгааллын аяныг зохион байгуулах ажлын хүрээнд аймгийн төвд 6 цэгт буюу дараах газруудад:<br>1. Арвижих багт Зоогийн 6-р гудамжны зүүн талын үзүүрт<br>2. Боржигон багт Боржигоны 11-р гудамжны зүүн үзүүрт<br>3. Нарлаг багт Мандал худалдааны төвийн урд талд, мөн БТСГ-ы баруун талд<br>4. Айраг багт Айрагийн 7-р гудамжны үзүүрт<br>5. Мандал багт Цагдаагийн газрын гаднах талбайд тус тус гэр мэдээллийн төвүүд байгуулж ажиллалаа. Иргэд, олон нийтэд “Хүүхэд хүмүүжлийн зерэг аргууд”, “Гэр бүлийн дүрэм бий болгох”, “Хүүхдийн хөгжлийн онцлог”, “Хүүхдийн аюулгүйн дүрэм” зэрэг сэдвүүдээр мэдээлэл өгч, сургалт зохион байгууллаа. Гэр мэдээллийн төвүүдийн үйл ажиллагаа тоон дүнгээр:<br>• Мандал баг 511 иргэн үүнээс 200 хүүхэд, 311 насан хүрэгч<br>• Арвижих баг 527 иргэн үүнээс 216 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | хүүхэд, 311 насанд хүрэгч<br>• Нарлаг-1 баг 1485 иргэн үүнээс 839 хүүхэд, 646 насанд хүрэгч<br>• Нарлаг-2 баг 292 иргэн үүнээс 115 хүүхэд, 177 насанд хүрэгч<br>• Боржигон багт 400 иргэн үүнээс 100 хүүхэд, 300 насанд хүрэгч<br>• Айраг багт 631 иргэн үүнээс 217, 414 насанд хүрэгч буюу Сайнцагаан сумын нийт 3864 иргэд, хүүхдүүд гэр мэдээллийн төвүүдээр үйлчлүүлсэн байна.<br><br>Тус аяны үр дүнд эцэг эх, асран хамгаалагчид хүүхэд хамгааллын талаарх ойлголт нь нэмэгдэж, бага насны хүүхдэдээ тавих анхаарал сайжрах, мэдээ мэдээллээр хангагдсан зэрэг давуу талтай үйл ажиллагаа болсныг тэмдэглэн хэлж, талархал илэрхийлж байлаа. | |
| 1.2 Байгууллага, аж ахуй нэгжийн дэргэдэх "Гэр бүлийн зөвлөл"-ийн үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх | **Тоо: 2 удаа**<br>**Чанар:**Хөтөлбөр хуваарь гарган батлуулж, зөвлөмж хүргүүлсэн байх<br>Хугацаа: Жилдээ | Зөвлөмжийн дагуу үйл ажиллагаа сайжирсан байна. | Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар 2014 оныг "Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил" болгон зарласантай холбоотойгоор Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын А/10 дугаар тушаал, аймгийн Засаг даргын А/145 дугаар захирамжийн хавсралтын 1.5 дахь заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэд гэр бүлийн хөгжлийг дэмжих жилд "Гэр бүлийн зөвлөл"-ийг байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах арга | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | хэмжээ тусгагдсан. Манай газраас 2014 оны 06 дугаар сарын 10-ны өдөр албан байгууллага, аж ахуй нэгжийн ажилтнуудтай хамтран, гэр бүлийн зөвлөлийн ажиллах журмыг боловсруулан, гэр бүлийн зөвлөлийг байгуулан ажиллах тухай албан тоотыг хүргүүлж байсан. Үүний дагуу 2017 оны 09 дүгээр сард Аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний 23 байгууллагын Гэр бүлийн зөвлөлийн үйл ажиллагаатай танилцахад байгууллагын даргын шийдвэрээр гэр бүлийн зөвлөлөө байгуулж, жилийн төлөвлөгөө гарган ажиллаж байгаа 12 байгууллага, даргын шийдвэрээр гэр бүлийн зөвлөлөө байгуулсан боловч үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаагүй 3 байгууллага, огт гэр бүлийн зөвлөлгүй 6 байгууллага байна. 2 байгууллагын гэр бүлийн зөвлөл хариуцсан мэргэжилтэн байхгүй байсан учир товлосон хугацаанд үйл ажиллагаатай нь танилцаж чадаагүй болно. Иймд гэр бүлийн зөвлөлгүй, гэр бүлийн зөвлөлөө шинэчлэн байгуулах шаардлагатай албан байгууллагууд даргын шийдвэрээр гэр бүлийн зөвлөлөө байгуулан, ажлын төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тайлагнах шаардлагатай байгааг мэдээлэн, зөвлөмж хүргүүлэн ажиллалаа .<br><br>Дийлэнх байгууллагууд гэр бүлд чиглэсэн спортын арга хэмжээ, хүүхдийн эрхийг | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | хамгаалах өдрөөр байгууллагын албан хаагчдын хүүхдүүдээ баярлуулах зэрэг үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж хэвшсэн байна.<br><br>Цаашид гэр бүлийн зөвлөлийн ажлын төлөвлөгөөндөө гэр бүлд чиглэсэн үйл ажиллагааг нарийн төлөвлөн оруулж, спорт, урлаг, оюун ухааны гэх мэт үйл ажиллагааны төрлөө нэмэгдүүлэн ажиллавал илүү үр өгөөжтэй байх бөгөөд тэдгээрийн гэр бүлд шаардлагатай байгаа сургалтын хэрэгцээг тодорхойлон, тухайн чиглэлээр мэргэшсэн хүнийг сонгон сургалтуудыг зохион байгуулвал илүү хүртээмжтэй болохыг нийт байгууллагын гэр бүлийн зөвлөлийн гишүүдэд зөвлөлөө. | |
| 1.3 Хүүхдийн паркийн мөсөн гулгуурын талбайг томсгож шинэчлэх | **Тоо:** 1 удаа<br>**Чанар:** Мөсөн гулгуурын талбайг томсгож шинэчлэсэн байх<br>**Хугацаа:** Жилдээ | Аюулгүй орчин бүрдэж, үйлчлэгээний хүртээмж сайжирч, үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдсэн байна | Хүүхдийн паркийн мөсөн гулгуурын талбайн уртын хэмжээ 30 метр, өргөний хэмжээ 21 метрийн урттай байсныг шинэчлэн, уртыг 43 метр болгон талбайн хэмжээг томсгож, мөсөн гулгуурын талбайг бэлтгэн, мөсийг хөлдөөж, хүүхэд багачууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна. | 100% |
| 1.4 Хүүхдийн паркийн тоглоомын тоог нэмэгдүүлэх | **Тоо:** 1 удаа<br>**Чанар:** тоглоомын тоог нэмэгдүүлсэн байх<br>**Хугацаа:** Жилдээ | Үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдсэн байна. | 2017 оны байдлаар Хүүхдийн паркт 10 төрлийн цахилгаан тоглоомыг шинээр худалдан авч, 2 тоглоомыг ашиглалтад оруулан ажиллуулж, хүүхэд багачуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд анхаарсны үр дүнд Хүүхдийн паркаар | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдээд байна. | |
| 1.5 Хүүхдийн паркийн хашааг шинэчлэх | **Тоо:** 1 удаа<br>**Чанар:** Хашааг шинэчилсэн байх<br>**Хугацаа:** Жилдээ | Аюулгүй орчин бүрдэж, өнгө үзэмж хамгаалалт сайжирсан байна. | Хүүхдийн паркийн гадна хашааны ажлын зураг төсвийг хийлгүүлж, 2018 оны төсвийн төсөлд холбогдох саналаа тусгуулаад байна. | 70% |
| 1.6 “Бүрдийн уянга” хүүхдийн зуслангийн гадна хашаа, тоглоомын талбайн тохижилтын ажлыг гүйцэтгэнэ. | **Тоо:** 1 удаа<br>**Чанар:** гадна хашаа болон тогроомын талбайн тохижилтыг ашиглалтад хүлээн авсан байх<br>**Хугацаа:** Жилдээ | Зусланд амрагчдын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх таатай орчин нөхцөл бүрдэж, аюулгүй байдал сайжирсан байна. | “Бүрдийн уянга” хүүхдийн зуслангийн гадна хашааны ажлын зураг төсвийг хийлгүүлж, 2018 оны төсвийн төсөлд холбогдох саналаа тусгуулан, биеийн тамирын талбайг тоног төхөөрөмжтэй болгохоор Чехийн элчин сайдын яаманд төсөл хүргүүлээд байна. | 70% |
| 1.7 “Бүрдийн уянга” хүүхдийн зуслангийн хөгжлийн хөтөлбөрийн нэр төрлийг нэмэгдүүлж гадаад харилцааг өргөжүүлэх | Тоо: 1 удаа<br>Чанар: 1 ээлжинд хэрэгжүүлсэн байх<br>-Нэр төрөл нэмэгдсэн байх<br>Хугацаа: 3-р улиралд | Үйлчилгээний нэр төрөл 1-р нэмэгдэж, амрагч хүүхдийн тоо өмнөх оныхоос 20%-иар өссөн байна. | Зусланд амрагч хүүхдийг хөгжүүлэх хөгжлийн хөтөлбөрийн нэр төрөл нэмэгдэж, 2017 онд 162 хүүхдийг зусланд амраасан нь өмнөх 2016 оныхоос 15 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. ОХУ-ын Буриад, БНХАУ-ын Эрээн хотын удирдлагуудтай зусланд амрагч хүүхдийг харилцан соилцож амраах талаар АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс болон ГБХЗХГ хамтран ажиллаж байна. | 100% |
| 1.8 Хүүхэд гэр бүлийн эрх хөгжлийг хангах чиглэлийн тэмдэглэлт өдрийг тохиолдуулан хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын үйл ажиллагааг олон нийтэд | **Тоо:** 10 нэгдсэн арга хэмжээ<br>**Чанар:** Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын үйл ажиллагааг олон нийтэд таниулах, сурталчилсан байх<br>**Хугацаа:** Жилдээ | Үйл ажиллагааг олон нийтийг мэдээллээр хангаж, ил тод сурталчлах нөлөөллийн ажлыг хийсэн байна. | -2017 оны 06 дугаар сарын 19, 20-ны өдрүүдэд ХНХ-ын яамны харьяа байгууллагуудын “Нээлттэй өдөрлөг”-ийг аймгийн ХХҮГ, ЭМНДХ, МСҮТ-тэй хамран зохион байгуулж, иргэдэд хүүхэд хүүхэд хамгааллын тухай, хүүхдийн эрхийн тухай хууль болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг сурталчлан, зөвлөгөө мэдээлэл өгч, гарын авлага тараан ажиллалаа.<br>-Дэлхийн гэр бүлийн өдөр буюу 05 дугаар сарын 15-ны өдрийг тохиолдуулан 5 | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| таниулах, сурталчлах нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах | | | номинацийн дагуу аймгийн “Тэнгэрлэг гэр бүл”-үүдийг шалгаруулан, алдаршуулах үйл ажиллагааг зохион байгууллаа.<br>-08 дугаар сарын 08 буюу Аавуудын өдрийг тохиолдуулан “Би аавтайгаа адилхан” гэрэл зургийнуралдааныг зохион байгууллаа. Тус уралдааны эхний 3 байрыг шалгаруулан шагнасан бөгөөд уралдаанд оролцсон гэр бүлүүдээс гэр бүлийн халуун дулаан урр амьсгалыг бүрдүүлэхэд эерэг нөлөөтэй сайхан үйл ажиллагаа байсныг хэлж байлаа.<br>-10 дугаар сарын 11 буюу Охидын өдөрт зориулан ЕБС-ийн дунд ахлах, ангийн охидод “Охидын шивнээ” болон “Гэр бүл төлөвлөлт” сэдэвт өртөөчилсөн сургалтуудыг зохион байгууллаа. Тус сургалтын үр дүнд өөрт тулгамдсан бэрхшээлтэй асуудлыг хэрхэн шийдвэрлэх, хэнд хандах, аливаа эрсдлээс өөрийгөө сэргийлэх зэрэг олон аргад суралцлаа.<br>-Жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны өдрөөс 12 дугаар сарын 10-ны өдрүүдэд дэлхий нийтээрээ "Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян"-ыг тэмдэглэн өнгөрүүлдэг билээ. Тус аянд Дундговь аймгийн ГБХЗХГ-ын хамт олон нэгдэж, "Цагаан тууз"-ыг зүүж уриалга гарган бусад байгууллагуудыг аянд нэгдэхийг уриаллаа. | |
| 1.9 Хүүхэд, өсвөр үе залуучуудад гэр бүлийн боловсрол олгох өртөөчилсөн сургалт зохион | **Тоо:** 10 удаа<br>**Чанар:** Сургалтын хөтөлбөр төлөвлөгөө гарсан байх | Хүүхэд, өсвөр үе залуучуудыг гэр бүлийн амьдралд бэлтгэсэн байна. | -Өсвөр үе, залуучуудад гэр бүлийн боловсрол олгох зорилгоор Сайнцагаан сумын ЕБС-удын дунд ангийн 175 эмэгтэй сурагчдад “Охидын шивнээ” сэдэвт сургалтыг, ахлах ангийн болон МСҮТ-ийн 150 эмэгтэй сурагчид | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| байгуулах | **Хугацаа:** Жилдээ | | “Гэр бүл төлөвлөлт” сэдэвт нийт 11 удаагийн өртөөчилсөн сургалтыг зохион байгууллаа. Ингэснээр охид өөрт тулгарсан бэрхшээлтэй асуудлаа хэрхэн шийдвэрлэх, хэнд хандах, өсвөр насандаа эрсдэлд өртөхгүй байх зэрэг олон зүйлийг ойлгож, өөрсдийн амьдралд хэрэгжүүлэх чадвар эзэмшлээ.<br><br>-ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг ГБХЗХГ-аас санаачлан улсын хэмжээнд 2017 оны 10 дугаар сарын 09-20-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “ЭЕРЭГ ХАНДЛАГА-ЭРҮҮЛ ОЮУТАН” аяны хүрээнд аймгийн МСҮТ-ийн оюутнуудад дараах өртөөчилсөн сургалтуудыг зохион байгууллаа. Үүнд:<br>-Дотуур байрны 40 оюутанд “Залуучуудын хөгжлийг дэмжих тухай” хууль, “Хорт зуршил гэж юу?, Хорт зуршлаас урьдчилан сэргийлэх аргууд”, “Оюутан залуучуудад зориулсан эрүүл мэндийн үйлчилгээ” сэдэвт өртөөчилсөн сургалтыг<br>-МСҮТ-ийн 90 оюутанд Эрүүл мэнд, нийгмийн даатгалын газартай хамтран<br>• Зөв амьдрах 8 мөр<br>• Эерэг харилцаа гэж юу вэ?<br>• Эрүүл мэндийн даатгалын тухай болон даатгалд хамрагдахын ач холбогдол<br>• “Залуучуудын хөгжлийг дэмжих тухай” хууль<br>• Хорт зуршлаас урьдчилан сэргийлэх аргууд зэрэг сэдвүүдээр өртөөчилсөн сургалтыг тус тус зохион байгуулж ажиллалаа. | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1.10 Олон хүүхдүүдтэй, өрх толгойлсон эцэг эх бүхий гэр бүл болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгэм сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх | **Тоо:** 1 удаа<br>**Чанар:** Нийгэм сэтгэл зүйн дэмжлэг үзүүлсэн байх<br>**Хугацаа:** Жилдээ | Зорилтод гэр бүлүүд нийгмийн амьдралд тэгш хүртээмжтэй оролцох орчин бий болсон байна. | -Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар зөвлөлийн хуралд 8 удаа оролцож, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн асуудлыг хэлэлцэн, салбар дундын байгууллагуудтай хамтран ажиллалаа. Зөвлөлийн хурлаар орсон хүүхэд, эцэг эхчүүдэд сэтгэлзүйн анхан шатны зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэн ажиллалаа.<br>-Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан 2017 оны 5-р сарын 24-нд Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, “Дэлхийн зөн Дундговь” орон нутгийн хөгжлийн хөтөлбөр, ХБИ-ийн холбоотой хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ сонсох өдөр”-ийг зохион байгууллаа. Өдөрлөг хэлэлцүүлэгт Сайнцагаан сумын хөгжлийн бэрхшээлтэй 50 хүүхэд асран хамгаалагчтайгаа хамрагдлаа. Тус өдөрлөгийн үеэр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд “Эрүүл мэнд” “Боловсролын орчин” “Нийгмийн хандлага” “Дэд бүтэц” хүрээнд тулгамдсан асуудлаа ярилцан, “Хүүхдийн дуу хоолой ба үр нөлөө” хүүхдээ сонсох өдрийн нүүр тулсан уулзалтад оролцох төлөөлөгчийг сонголоо. Мөн хүрэлцэн ирсэн хүүхдүүддээ хүндэтгэл үзүүлж 6-р цэцэрлэгийн бяцхан хүүхдүүд урлагийн тоглолт үзүүлж, “Бүрд” ХХК, “ЭОЖИН” ХХК, “Тогоогийн говь” ХХК, “Өнөмөнх хайрхан” ХХК-иуд оролцогч хүүхдүүдэд гарын бэлэг гардуулж, Хүүхдийн паркийн тоглоомуудад үнэ төлбөргүй тоглууллаа.<br>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд хүндэтгэл үзүүлэн, тэдний дуу хоолойг сонсож, дээрх сэдвүүдийн хүрээнд орон нутагт хэрэгжүүлэх | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | шаардлагатай асуудлыг гарган нэгтгэж, хүн нэг бүрийн саналыг тусгасан онцлогтой үйл ажиллагаа боллоо.<br>-Монголын “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн холбоо”-ноос орон нутагт ажилласан багийн бүрэлдэхүүнд орж, үзлэг оношилгоо хийлгэхээр ирсэн 36 хүүхдийн эцэг эхэд сэтгэл зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.<br>- "Major drilling" компанитай хамтран аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоонд 1.200.000 төгрөгийн үнэ бүхий хүчилтөрөгчийн аппарат, хүрэлцэн ирсэн бүх хүүхдүүдэд витамин бүхий гарын бэлэг, хөгжлийн бэрхшээлтэй хэвтэрт байдаг 2 хүүхдэд хүнсний тусламж, гарын бэлэг Өлзийт сумын хөгжлийн бэрхшээлтэй 1 хүүхдэд маникурын иж бүрэн хэрэглэл гардуулан өглөө.<br>-2017 оны 10 дугаар сарын 18-ны өдөр аймгийн Засаг даргын “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ сонсох өдөр”-ийн нүүр тулсан уулзалтыг орон нутгийн удирдах ажилтан, сургуулийн нийгмийн ажилтан, ХБХ-ийн эцэг эхийн төлөөлөл, хүүхдийн төлөөлөл 70 хүнийг оролцуулан зохион байгуулж, ХБХ-ийн өмнө тулгамдаж байгаа асуудыг эрэмбэлэн, ажлын төлөвлөгөө гарган, аймгийн Засаг дарга, хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүнээр батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | |
| 1.11 Хүүхдийн хүмүүжил төлөвшилд үндэсний өв | **Тоо:** 3 удаа<br>**Чанар:** Удирдамж, төлөвлөгөө гарсан байх | Түүх соёл, үндэсний өв соёлоор дамжуулан олон | -Монгол Улс тунхагласны түүхт 93 жилийн ойн баярын өдрийг тохиолдуулан Монгол улсын "ИРГЭНИЙ АНДГАЙ ӨРГӨХ ЁСЛОЛ"-ыг зохион байгуулсан бөгөөд тус үйл ажиллагаанд | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| соёлоор дамжуулан нөлөөлөх арга хэмжээг зохион байгуулах | **Хугацаа:** Жилдээ | нийтэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулсан байна. | аймгийн МСҮТ болон Сайнцагаан сумын ерөнхий боловсролын сургуулиудын сурагчид оролцож, шилдэг 33 сурагч орон нутгийн удирдлагуудаас иргэний үнэмлэхээ гардан авч, нийт 125 сурагч иргэний андгай өргөлөө.<br>-Энэхүү үйл ажиллагаа нь өсвөр үе, залуучуудад эх орон, түүх соёлоороо бахархах, үндэсний үзэл төлөвшүүлэх, хариуцлагатай иргэн байх зэргийг ухамсарлуулахад ач холбогдолтой үйл ажиллагаа боллоо. | 70% |
| 1.12 Аймгийн хүүхдийн 11-р чуулганыг зохион байгуулж, сум орон нутгийн хөгжилд хүүхдийн оролцоог нэмэгдүүлнэ. | **Тоо**: 1 удаа<br>**Чанар:** Аймгийн хүүхдийн чуулганаас шийдвэр гарсан байх<br>Чуулганы шийдвэрийг хэрэгжүүлсэн байх<br>**Хугацаа:1-2 улирал** | Хүүхдүүд тулгамдсан асуудлаа дэвшүүлж, үүрэг хүлээгч нар тэдний дуу хоолойг сонсон хэрэгжүүлсэн байх | Хүүхдийн нийгэмд оролцох оролцоог нэмэгдүүлэх, өөрт хамаарах аливаа асуудлаар шийдвэр гаргах, үнэлэлт өгөхөд оролцож, хуулиар олгогдсон эрхээ эдлэх, шаардах, бүлэг хамт олноор дамжуулан боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын асуудал, үе тэнгийн хүчирхийлэл, дарамтыг бууруулах зорилготой “Хүүхдийн дуу хоолой ба үр нөлөө” аймгийн хүүхдийн 11-р чуулганыг “Би том гартай ч хүчирхийлэгч биш” уриатайгаар 2017 оны 02 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд аймгийн Засаг даргын Тамгын газар, ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, “Дэлхийн зөн Дундговь” ОНХХ, “Оюуны гэгээ” сургуулийн нийгмийн ажилтны нийгэмлэгтэй хамтран зохион байгууллаа. Чуулганд оролцсон төлөөлөгч хүүхдүүд “Дотуур байр миний 2 дахь гэр”, “Хүүхдэд ээлтэй багш”, “Цахим орчны зөв зохистой хэрэглээ”, “Сургууль дахь найз | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | нөхдийн нөхөрсөг харилцаа", "Хөгжих орчин ба чөлөөт цаг" гэсэн 5 бүлгийн хүрээнд хэлэлцэж, "Оноо өгөх" аргачлалыг ашиглан тулгамдаж буй асуудлаа гарган, жүжиг, зураг, дуу, шүлгийн аргаар шийдвэр гаргах түвшнийхэнд дуу хоолойгоо хүргэлээ. Мөн төлөөлөгч хүүхдүүд гаргасан шийдвэрээ хүүхдийн төлөө аймгийн зөвлөлийн дарга, бусад салбар дундын байгууллагын удирдлагуудад бичгээр хүлээлгэн өглөө. | |
| 1.13 Залуучуудын чуулганыг зохион байгуулж, сум орон нутгийн хөгжилд залуучуудын оролцоог нэмэгдүүлнэ. | **Тоо**: 1 удаа<br>**Чанар:** Аймгийн залуучуудын чуулганаас шийдвэр гарсан байх Чуулганы шийдвэрийг хэрэгжүүлсэн байх<br>**Хугацаа:1-2 улирал** | -Залуучууд тулгамдсан асуудлаа дэвшүүлж, чуулганы шийдвэрийг хэрэгжүүлсэн байх<br>-Залуучуудын нэгдсэн мэдээллийн сан бүрдсэн байх | -Аймгийн залуучуудын чуулганыг зохион байгуулах төлөвлөгөө, төсвийн тооцоог боловсруулан бэлтгээд байна. Хөрөнгөний эх үүсвэрээс шалтгаалан зохион байгуулагдаагүй байна.<br><br>-Аймгийн хэмжээний 15-34 насны залуучуудын судалгааны асуулгыг боловсруулан, 15 сум, аймгийн засаг даргын эрхлэх хүрээний харьяа хэлтэс, агентлагуудын судалгааг нэгтгэн мэдээллийн сан үүсгээд байна. | 50% |
| 1.14 Залуучуудын гарааны бизнесийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ХХҮГ, ХАҮТ-тай хамтран ажиллаж тоног төхөөрөмжийн лизенгийн | **Тоо:** 1 удаа<br>**Чанар:** 18-35 насны залуучуудад бизнесийн дэмжлэг үзүүлсэн байх<br>**Хугацаа**: Жилдээ | Санхүүгийн арга ухаанд суралцаж, мэдлэг чадвар дээшилсэн байх | -2017 оны 11 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газартай хамтран залуучуудын гарааны бизнесээ эхлэх, аж ахуй, бизнес эрхлэх ур чадвар, шилдэг санаанд тулгуурлан санхүүгийн дэмжлэг олгох зорилгоор "Start-up Weekend" туршилтын арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. Тус үйл ажиллагааны хүрээнд: | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| үйлчилгээнд хамруулах арга хэмжээ авна. | | | -Туршилтын төсөл хөтөлбөрт 15-34 насны нийт 54 залууг хамруулан, бизнесийн шинэлэг, шилдэг санаагаа уралдуулах боломжийг олгосноор, нийт 12 баг төсөл бэлтгэн оролцсоноос шилдэг 5 багийг шалгаруулан, дараагийн шатны сургалтад хамруулж, шилдэг 1 төслийг шалгаруулан, бизнесээ эхлүүлэх, хөгжүүлэхэд зориулан 2 жилийн хугацаанд ямар ч хүүгүйгээр эргэн төлөх боломжтой 10 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлэн ажиллаж байна. | |
| 1.15 Өрх гэр бүл, эцэг эхийн үүрэг хариуцлага мэдлэг чадвар хандлагад нөлөөлөх гэр бүлийн боловсрол олгох модуль сургалт зохион байгуулах | **Тоо**: 50 өрхөд<br>**Чанар:** Сургалт хөтөлбөр төлөвлөгөө гарсан байна.<br>**Хугацаа:** Жилдээ | Гэр бүлийн боловсрол олгох модуль сургалт зохион байгуулсан байна. | Сайнцагаан сумын зорилтот 50 өрхийг сонгон 2017 оны 1 дүгээр улиралд 2 сарын хугацаатай “Жаргалтай гэр бүл” аяныг өрнүүллээ. Тус аяны хүрээнд гэр бүлийн боловсрол олгох<br>1.Хувь хүн өөрийгөө таних, удирдах чадвар<br>2.Гэр бүлийн харилцаа үнэт зүйл<br>3.Харилцааны ур чадвар ба ёс суртахуун<br>4.Гэр бүлийн хүчирхийлэл ба ёс суртахуун<br>5.Хүүхдийн эрх хамгаалал, үүрэг оролцоо<br>6.Амьжиргааг дэмжих нийгмийн хамгаалал, эрх зүйн орчин<br>7.Хөдөлмөр эрхлэлт<br>8.Эрүүл харилцаа ба аз жаргалтай гэр бүл сэдэвт 8 модуль сургалтыг аймгийн Сургалт судалгааны хүрээлэн ТББ-тай хамтран зохион байгууллаа. | 100% |
| 1.16. Хүүхдээ сонсох өдрөөр дамжуулан, тэдний саналыг сонсож асуудлыг шийдвэрлэсэн | **Тоо:** 11 удаа<br>**Чанар:** Захирамж, удирдамж гарсан байх<br>**Хугацаа:** Жилдээ | Захирамжийн дагуу хүүхдээ сонсох өдрийг зохион байгуулж, үр дүнг | Гэр бүл Хүүхэд Залуучуудын Хөгжлийн Газар, “Дэлхийн Зөн Дундговь” орон нутгийн хөгжлийн хөтөлбөртэй хамтран хүүхдүүд өөрт хамаарах аливаа асуудлаар шийдвэр гаргах үнэлэлт өгөхөд оролцох, хуулиар олгогдсон эрхээ | 70% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| байна | | тайлагнасан байна. | эдлэх, шаардах, тэдний нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах зорилготойгоор Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор “Хүүхдийн дуу хоолой ба үр нөлөө“ нэртэй хүүхдээ сонсох өдөртэй болсон. Тус ажлын хүрээнд ажлын хэсгийн 26 гишүүдийг чадваржуулах “Иргэдийн дуу хоолой түүний үр нөлөө” аргачлал сургалтыг зохион байгуулж, жилийн төлөвлөгөөг гарган ажиллаж байна. Жилийн ажлын төлөвлөгөөний дагуу “Уралдаанч” хүүхэд, “СОУЗ”-ийн хүүхэд, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, “Цахим орчин дахь хүүхэд хамгаалал” сэдвийн хүрээнд урьдчилсан хэлэлцүүлгийг нийт 282 хүүхдийг хамруулан зохион байгуулж, тэдэнд тулгамдаж буй асуудлуудыг гаргаж, СОУЗ-ын хүүхдүүдэд тулгамдаж байгаа асуудал болон Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тулгамдаж буй асуудлыг удирдах, шийдвэр гаргах түвшний албан тушаалтнуудад танилцуулан, нүүр тулсан уулзалтыг зохион байгуулж, гаргасан саналыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг аймгийн Засаг дарга баталж, холбогдох албан тушаалтнуудад хүргүүллээ. | |
| **НИЙТ АРГА ХЭМЖЭЭ-16** | | | 268,050 мянга | |
| **Хоёр. “Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил, хамгааллыг дэмжих, бүх шатны төрийн, төрийн бус байгууллага, хувийн хэвшил, олон улсын байгууллага, иргэд, олон нийтийн оролцоо, түншлэлийг бэхжүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ** | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2.1. Шинээр болон шинэчлэгдэн батлагдсан хуулийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргах, сургалт зохион байгуулах | **Тоо:** 5 удаагийн сургалт<br>**Чанар:** Төлөвлөгөөг хэрэгжүүлэн сургалт, нөлөөлөл, сурталчилгааны ажлууд хийгдсэн байна.<br>**Хугацаа:**Жилдээ | Сургалт зохион байгуулж, олон нийтэд зориулсан нөлөөлөл, сурталчилгааны ажлууд хийгдсэн байна | -"Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай" хуулийн шинэчилсэн найруулгыг иргэд, олон нийтэд сурталчлах ажлын хүрээнд: АЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэстэй хамтран, "Хүчирхийллийн эсрэг хамтдаа" сарын аяныг зохион байгууллаа.<br><br>Тус аяны хүрээнд сумдын нийгмийн бодлогын 15 мэргэжилтэн, Сайнцагаан сумын 20 иргэн, "Эрдмийн далай" цогцолбор сургуулийн 50 багш, Хулд сумын 120 иргэнд "Гэр бүлийн хүчирхийлэл", шинэчлэн батлагдсан "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 10 гол өөрчлөлт" зэрэг сэдвээр сургалт зохион байгуулж, 100 ширхэг брошур олшруулан, иргэдэд тараан, мэдээлэл өгч ажилласан бөгөөд 2017 оны байдлаар "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг нийт хүн амын 1/3 буюу 15117 иргэнд хүргэж ажиллахаас Сайнцагаан сумын 3785, Дэрэн сумын 309, Цагаандэлгэр сумын 31, Дэлгэрхангай сумын 200, Сайхан-Овоо сумын 844, Эрдэнэдалай сумын 863, Баянжаргалан сумын 50, Өндөршил сумын 370, Адаацаг сумын 566, Гурвансайхан сумын 975, Дэлгэрцогт сумын 486, Луус сумын 230, Хулд сумын 470 нийт 8894 иргэн буюу | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | 15117 иргэний 58.8%-д хүрч ажиллаад байна.<br><br>-Сайнцагаан сумын 159 иргэнд Хүүхэд хамгааллын тухай хуулийг сурталчлах сургалтыг зохион байгууллаа.<br><br>-2017 оны 05 дугаар сарын 18-ны өдөр батлагдсан Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль нь 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжихтэй холбогдуулан, хууль сурталчлах ажлыг шат дараатай зохион байгуулж ажиллалаа.<br><br>1. Сайнцагаан сумын аж ахуй нэгж, албан байгууллагуудад хууль сурталчлах сургалтыг зохион байгуулж, нийт 353 иргэнд мэдээлэл хүргэж ажиллалаа.<br><br>2. 2017 оны 11 дүгээр сарын 13-26-ны өдрүүдэд 15 суманд "Залуучуудын хөгжлийг дэмжих тухай" хууль сурталчлах 14 хоногийн аяныг зохион байгуулж, нийт 5404 иргэн, 15-34 насны 4025 залууст хуулийн мэдээллийг хүргэж ажиллалаа. | |
| 2.2 Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг идэвхижүүлж гэмт хэрэгт холбогдсон | **Тоо:** 1 удаа<br>**Чанар**: Үйл ажиллагаа сайжирсан байх<br>-Гэмт хэргийн шалтгаан нөхцлийг | Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагаа тогтмолжиж гэмт хэрэг, зөрчилд | -Аймгийн Засаг даргын 2017 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн А/67 дугаар захирамжаар Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог 17 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.<br>-Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны 2017 | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| хүүхдийг эерэгжүүлж, гэрч хохирогчийг хамгаалах | судалсан байх<br>**Хугацаа:** 2-р улиралд | холбогдсон хүүхдүүдийн эрх хамгаалагдсан байна. | оны ажлын төлөвлөгөөг хорооны даргаар батлуулан, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Хууль зүйн дотоод хэргийн сайдын 2017 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А51/А69 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, ажлын чиг үүрэг”-ийг танилцуулан 3 цагийн сургалт зохион байгууллаа.<br>-Гурвансайхан сумын хууль зөрчсөн 2 хүүхэдтэй ажиллах ажлын төлөвлөгөө боловсруулан Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны даргаар батлуулан ажиллаж, хууль зөрчсөн 2 хүүхэд болон эцэг эхтэй уулзаж, өмгөөлөгч авах хүсэлтэй 1 хүүхдийн ээжийг өмгөөлөгтэй холбон зуучилж, сумын хамтарсан багаас гаргасан нөхцөл байдлын үнэлгээтэй танилцан, цаашид авах арга хэмжээний талаар сумын хамтарсан багт чиглэл, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллалаа.<br>-2018 оны 01 дүгээр сард ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг ГБХЗХГ-тай хамтран Хууль зүйн хорооны гишүүдийг чадваржуулах сургатыг зохион байгуулахаар төлөвлөөд байна. | |
| 2.3. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах чиглэлээр 2017 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө батлан | **Тоо:** 1 төлөвлөгөө, 1 тайлан<br>**Чанар:** Төлөвлөгөөг хэрэгжүүлэн сургалт, нөлөөлөл, сурталчилгааны ажлууд хийгдсэн байна | Төлөвлөгөөний дагуу хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн байна. | -Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах чиглэлээр 2017 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газартай хамтран баталсан. Тус төлөвлөгөөний дагуу хүүхдийн хөдөлмөрийн талаарх олон нийтийн | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| хэрэгжүүлэх | **Хугацаа:**2-3 улиралд | | ойлголт хандлагыг нэмэгдүүлэх замаар хүүхдийн хөдөлмөрийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилготой 2 сарын аяны удирдамж боловсруулан сумдад хүргүүлсэн. Тус аянд 4 сумын 832 хүүхэд, 978 насанд хүрэгч, 43 албан байгууллага оролцсон. Мөн “Хүүхдэд аюултай хөдөлмөр” сургалтыг сумдын нийгмийн бодлогын ажилтнуудад зохион байгуулж, сургалтын багцыг хувилан сумдын хамтарсан багт хүргүүлэн ажиллалаа. | 100% |
| 2.4 Хурдан морины уралдаанч хүүхдийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг хангах стандарт мөрдүүлж ажиллах | **Тоо:** 3<br>**Чанар:** Хүүхдийн аюулгүй байдлыг ханган хамгаалалтын хэрэгсэлд хяналт тавьж ажилласан байх<br>**Хугацаа:**2-3 улиралд | Уралдаанч хүүхдүүдийн эрх аюулгүй байдал хангагдсан байна. | Хүүхдийн язгуур эрх ашгийг хамгаалах, хэрэгжүүлэх, хүүхдэд тулгамдаж буй асуудлыг цаг тухай бүрд нь шийдвэрлэх зорилгоор Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2017 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн №10 тоот тогтоолоор “Хүүхдийн дуу хоолой ба үр нөлөө” өдрийг сар бүрийн 03-05-ны өдрүүдэд зохион байгуулж байхаар шийдвэрлэсний дагуу 2017 оны 05 дугаар сарын 03-ны өдөр “Уралдаанч” хүүхдээ сонсох урьдчилсан хэлэлцүүлэг арга хэмжээг зохион байгууллаа. Уг хэлэлцүүлэгт Сайнцагаан сумын 70 уралдаанч хүүхдийн төлөөлөл оролцож, “Уралдаанч” хүүхдүүдийн өмнө тулгамдсан асуудлыг сонсож Монгол улсын MNS6264:2011 хамгаалалтын | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | хувцас, хэлэгсэлд тавигдах стандартад оноо өгөх аргачлалаар үнэлгээ хийлгэж, цаашид орон нутгийн түвшинд анхаарах, шийдвэрлэх асуудлаа гаргалаа.<br><br>Орон нутгийн хэмжээнд зохион байгуулагдаж буй бүх төрлийн баяр наадам, хурдан морины бооцоот уралдаан, үсэргээ, сунгаа, мялаалганы наадамд уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг ханган, хамгаалалтын хувцас хэрэгслийг өмсүүлэн оролцуулах талаар аймгийн Засаг даргын албан даалгаврыг сумдад хүргүүлэн ажиллалаа. Мөн аймгийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооноос хурдан морины уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг ханган ажиллах чиглэлээр анхааруулгыг сумдын Засаг дарга нар буюу сумын Хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүнүүдэд хүргүүллээ.<br><br>Засгийн газрын 2017 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 63 дугаар тогтоолоор 2017 оны 07 дугаар сарын 28-30-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Их мандал” говийн бүсийн хурдан морины уралдааны үеэр уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг ханганажиллалаа. Тус уралдааны үеэр Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас Наадмын үеийн уралдаанч хүүхдийн аюулгүй | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | байдлыг хангах, хяналт тавьж ажиллах 11 хүний бүрэлдэхүүнтэй баг гарч, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газартай хамтран ажиллалаа. Уралдаанд 9 насны 767 хурдан морийг 337 уралдаанч хүүхэд унаж хурдлуулсан бөгөөд уралдаанч хүүхдийг 100 хувь гэнэтийн ослын даатгалд хамруулж, хамгаалалтын малгай, өвдөгч, тохойвч, цээживчтэй уралдаанд оролцуулав.<br>Уралдааны үед гарааны төхөөрөмж дээр 3, уралдааны явцад 6, нийт 9 хүүхэд морь бүдрэх, булгих шалтгаанаас болж унасан боловч бэртэл гэмтэл авалгүй эмнэлгийн анхан шатны тусламжийг цаг алдалгүй яаралтай авсан. Унасан хүүхдийн бүртгэлийг газар дээр нь хийж баталгаажуулан ажилласан. Уяачид, эцэг эхчүүдэд тухай бүрд нь уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг хангах талаар гарын авлага тараан, зөвлөгөө өгч ажиллалаа. | |
| 2.5. Хүүхдийн тусламжийн утас 108-ийг сум, орон нутагт сурталчлан таниулж, 108-д ирсэн санал хүсэлтийг хэрэгжүүлж, эргэх | **Тоо:** 4 удаа<br>**Чанар:**108 утасны талаар мэдээллийг мэдээллийн хэрэгслээр сурталчилсан байх<br>**Хугацаа:**Жилдээ | Хүүхдийн тусламжийн 108 утасны талаар олон нийт мэдээлэлтэй болж эргэх холбоо сайжирсан байна. | -“Хүүхдийн эсрэг хүчирхийллийг зогсооход эх дэлхийгээрээ нэгдье” хүүхэд хамгааллын дэлхийн 7 хоног аянаар Сайнцагаан сумын хэмжээнд 6 гэр мэдээллийн төв байгуулж, 2159 насанд хүрэгч, 1687 хүүхэд нийт 3846 хүнд Хүүхдийн тусламжийн 108 утсыг танилцуулан сурталчилж ажиллалаа.<br>-Хүүхдийн тусламжийн 108 утаснаас 2017 | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| холбоог сайжруулан ажиллах | | | оны 12 сарын байдлаар 16 дуудлага ирсэн. Үүнээс хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдсэн 5, гэрээсээ дайжсан 2, зөвшөөрөлгүй хурдан морины уралдаан зохион байгуулсан болон мориноос унасан хүүхдийн дуудлага 2, багшийн ёс зүйтэй холбоотой 1, үе тэнгийн сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн 3, гэнэтийн ослоор нас барсан хүүхдийн талаарх дуудлага 3 тус тус ирж, 13 дуудлагыг шийдвэрлэж хариу хүргүүлж хаан, 3 дуудлагыг сумдын хамтарсан багт шилжүүлж, үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.<br><br>- Аймгийн хэмжээний ерөнхий боловсролын 19 сургуулийн дунд, ахлах ангийн нийт 1822 сурагчид Хүүхдийн тусламжийн 108 утсыг сурталчилж ажиллалаа. Тус үйл ажиллагааны хүрээнд: Хүүхдийн санаа бодлыг сонсох, хүүхдэд шаардлагатай сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээнд холбон зуучлах, бие махбодь, сэтгэцийн эрүүл мэндэд эрсдэлтэй тохиолдолд яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэх зорилготой “Хүүхдийн тусламжийн утас-108”-ийн талаарх мэдээллийг хүргэсэн. | |
| 2.6. Хүүхдийг гэмт хэрэг, хэв журмын | **Тоо:** 1 төлөвлөгөө<br>**Чанар:** Төлөвлөгөө | Хүүхдийг аливаа эрсдлээс | -Бага насны хүүхдийг осол, гэмтлээс сэргийлэх, эцэг эхийн хариуцлагыг | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| зөрчил, гэр бүлийн хүчирхийлэл, зам тээврийн болон ахуйн осол гэмтэл, цахим мэдээллийн сөрөг нөлөөнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр салбар дундын зохицуулалтыг хангах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх | баталж хэрэгжүүлсэн байх Төлөвлөгөөний хэрэгжилт гарсан байх **Хугацаа:**1-4 улирал | хамгаалах чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагааг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулсан байна. | өндөржүүлэх зорилготойгоор Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газартай хамтран үйл ажиллагааны төлөвлөгөө гарган ажиллалаа. Үүнд: Түлэгдэлтээс урьдчилан сэргийлэх болон анхан шатны тусламж үзүүлэх чиглэлээр аймаг, сумдын үүрэн телефоны нийт 20,000 хэрэглэгчдэд масс мессежээр дамжуулан мэдээллийг хүргүүлсэн. Аймгийн Онцгой байдлын Аюулаас сэргийлэх цогцолбор буюу FM-107.5-ын сонсогчдод аяны хүрээнд түлэгдэлтээс бага насны хүүхдээ урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлгийг 7 хоногт 1-2 удаагийн давтамжтайгаар 6 удаа мэдээ мэдээлэл хүргүүллээ. Сайнцагаан сумын гэр хорооллын нийт 628 өрхөд түлэгдэлтээс сэргийлэх талаар гарын авлага, тараах материал боловсруулан өрх бүрт тараасан. Сайнцагаан сумын цэцэрлэг болон ЕБС-ийн 300 эцэг эхчүүдэд сургалт зохион байгуулсан. “Дундговийн амьдрал” сонинд үйл ажиллагааны хүрээнд хийгдэж буй ажлын талаар мэдээлэл бэлтгэж, хэвлүүлсэн. Аймгийн ГБХЗХГ, Эрүүл мэндийн газар, Онцгой байдлын газрын цахим сайт, page хуудсанд видео бичлэг болон үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг 1 сарын хугацаанд тогтмол цагт байршуулж | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | байсан. ЕБС-ийн “Өсвөрийн аврагч” бүлгэмийн 50 хүүхдүүдэд түлэгдэлтээс урьдчилан сэргийлэх болон түлэгдсэн үед хэрхэн анхан шатны тусламж үзүүлэх талаар сургалт зохион байгуулж, тэднээр дамжуулан ЕБС-ийн сурагчид, СОУЗ-ийн гишүүд, хүүхэд хөгжүүлэх бүлгэм дугуйлангийн 350 сурагчдад сургалт видео бичлэгүүдийг хүргүүлсэн. Нийт 1328 иргэнд урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа зохион байгуулж хүүхдээр дамжуулан эцэг эх, асран хамгаалагчийн оролцоог нэмэгдүүлсэн. Дээрх үйл ажиллагаануудыг зохион байгуулсны үр дүнд эцэг эх асран хамгаалагчийн оролцоо, хариуцлага нэмэгдсэн. Осол гэмтэлд өртөн амь насаа алдсан хүүхдийн тоо өмнөх онд 10 байсан бол энэ оны эхний 9 сарын байдлаар 4 хүүхэд нас барж 6-р буурсан байна. | |
| 2.7. Хүүхдийн оролцоог дэмжих стратегийг 2017 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх | **Тоо:** 1 төлөвлөгөө, 1 тайлан<br>**Чанар:** Төлөвлөгөө гаргаж батлуулан хэрэгжиж эхэлсэн байх<br>**Хугацаа:** 1-4 улирал | Батлуулсан төлөвлөгөө хэрэгжиж эхэлсэн байна. | Хүүхдийн оролцоог дэмжих стратегийг 2017 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, Хүүхдийн оролцооны өөрөө удирдах байгууллагын гишүүдийг чадваржуулах, үйл ажиллагааг идэвхижүүлэх, үр дүнд хүргэх, чиглүүлэгч багш нарт мэдлэг олгох тэднийг чадваржуулах зорилгоор “Оролцоод | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
